



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (168)

Монгол Улсын Хууль:

- *Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны наймдугаар сарын 17.

№31 (168)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|--|---------------------|-----|
| 329. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | (2000-8-3-ны хууль) | 574 |
| 330. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | (2000-8-3-ны хууль) | 578 |
| 331. Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | (2000-8-3-ны хууль) | 578 |
| 332. Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | (2000-8-3-ны хууль) | 578 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|--|-----------|-----|
| 333. Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилж тухай | Дугаар 13 | 578 |
| 334. Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай | Дугаар 14 | 579 |
| 335. М.Болдыг Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 15 | 579 |
| 336. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай | Дугаар 16 | 580 |
| 337. Хууль, тогтоолын төсөл буцаах тухай | Дугаар 17 | 580 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|---|------------|-----|
| 338. Кэрэл Белламыг "АЛТАН ГАЦАС" одонгоор шагнах тухай | Дугаар 124 | 583 |
|---|------------|-----|

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|---|------------|-----|
| 339. Засгийн Газрын 2000 оны 101 дүгээр тогтоолын 2,3 дугаар хавсралт | | 584 |
| 340. Ой тэмдэглэх тухай | Дугаар 102 | 598 |

Уншигчдын анхааралд

"Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2000 оны 8 дугаар сарын 15-ны өдөр хориг тавьсан тул хуулийн тухайн заалтыг /Тус эмхтгэлийн 576 дугаар талд үз./ уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэгээл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн гуравдугаар бүлэг, 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай.

1/ГУРАВДУГААР БҮЛЭГ:

"ГУРАВДУГААР БҮЛЭГ"

Засгийн газар, түүний бүтэц

17 дугаар зүйл. Засгийн газар

1.Засгийн газар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс бүрдэнэ. Засгийн газрыг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлнэ.

2.Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Ерөнхий сайдын үүрэг болгосноор Засгийн газрын аль нэгэн гишүүн гүйцэтгэнэ. Ерөнхий сайдын үүргийг түр гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн нь Ерөнхий сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, хариуцлага хүлээнэ.

3.Засгийн газар үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ.

4.Танхимын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Засгийн газрын хуралдаан мөн.

5.Засгийн газар үйл ажиллагааныхаа тодорхой чиглэлээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар урьдчилан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй байж болно. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Засгийн газар тогтооно.

18 дугаар зүйл. Монгол Улсын яам

1.Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн.

2.Монгол Улсын яамыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн, Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн хуулиар байгуулж, татан буулгана.

3.Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн

- 1/Гадаад хэргийн яам;
- 2/Санхүү, эдийн засгийн яам;
- 3/Хууль зүй, дотоод хэргийн яам.

Чиглэлийн

- 4/Байгаль орчны яам;
- 5/Батлан хамгаалах яам;
- 6/Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 7/Дэд бүтцийн яам;
- 8/Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 9/Үйлдвэр, худалдааны яам;
- 10/Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- 11/Эрүүл мэндийн яам.

4.Монгол Улсын яамыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд тэргүүлнэ.

5.Сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, агентлагийн үйл ажиллагааг сайдын өмнө мэргэшлийн үндсэн дээр хариуцах үүрэг бүхий дэд сайд байна.

Дэд сайдыг Монгол Улсын Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

Монгол Улсын сайдын түр эзгүйд түүний үүргийг дэд сайд гүйцэтгэнэ.

6.Монгол Улсын сайд өөрийн ажлын хэсэгтэй байж болно. Сайдын эрхлэх ажлын хүрээн дэх чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд сайдад зөвлөх үүрэгтэй сайдын зөвлөл ажиллана. Сайдын зөвлөлийн ажиллах нийтлэг журам, сайдын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийг Засгийн газар тогтооно.

7.Монгол Улсын яам Төрийн нарийн бичгийн даргатай байна. Төрийн нарийн бичгийн дарга нь яамны аппаратын гүйцэтгэх ажлыг зохион байгуулан удирдаж, сайд үйл ажиллагаагаа шуурхай явуулахад шууд туслах үндсэн чиг үүрэгтэй. Төрийн нарийн бичгийн дарга нь Монгол Улсын сайд, дэд сайдаас өгсөн үүрэг даалгаврыг хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрт нийцүүлэн биелүүлнэ.

8.Төрийн нарийн бичгийн даргыг Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүгнэлтийг харгалзан Засгийн газар томилж, чөлөөлнө.

9.Төрийн нарийн бичгийн дарга эрх хэмжээнийхээ



хүрээнд Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангуулна.

10. Монгол Улсын яамны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

18^д дүгээр зүйл. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, түүний удирдлага

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын ажлын алба мөн.

2. Хэрэг эрхлэх газрыг Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга газрынхаа үйл ажиллагааг удирдахын хамт Засгийн газрын гишүүний хувьд энэ хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 12-т заасан ажлыг хариуцна.

4. Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцна.

5. Хэрэг эрхлэх газар энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан ажлыг эрхлэнэ.

18^д дугаар зүйл. Засгийн газрын агентлаг

1. Засгийн газар нь үйл ажиллагааныхаа зохих хүрээ, салбарт тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн бүүдүүвчийн дагуу байгуулан ажиллуулж болно.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн даргыг тухайн сайдын саналыг харгалзан Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.

3. Агентлагийн орлогч даргыг Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүгнэлтийг харгалзан Монгол Улсын сайд томилж, чөлөөлнө.

4. Агентлагийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

19 дүгээр зүйл. Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх

1. Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.

2. Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын

зохих сайдын өмнө хариуцна.”

2/20 дугаар зүйл:

“20 дугаар зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүн

1. Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

2. Засгийн газрын гишүүн нь Монгол Улсын сайд байна.

3. Ерөнхий сайд болон сайд нарын эрхлэх ажлын үндсэн хүрээг энэ хуулиар тогтооно.

4. Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд дараах асуудал хамаарна:

- 1/ тагнуул, сөрөг тагнуул;
- 2/ үндэсний радио, телевизийн асуудал;
- 3/ гадаад мэдээлэл;
- 4/ төрийн өмчийн бодлого;
- 5/ эдийн засгийн стратеги, төлөвлөлт.

5. Засгийн газрын гишүүн дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт, хэрэгжилт, улсын хяналт шалгалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхлэнэ:

1/ Монгол Улсын Гадаад хэргийн сайд:

- төрийн гадаад бодлого;
- гадаад орон, олон улсын байгууллагатай улс төрийн талаархи хамтын ажиллагаа;
- гадаад эдийн засгийн харилцаа;
- гадаад орон, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал, байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;
- гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудал;
- виз, консулын асуудал;
- гадаад оронтой хүмүүнлэгийн чиглэлийн хамтын ажиллагаа.

2/ Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайд:

- эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзэл баримтлал, хэтийн бодлого, тогтвортой хөгжлийн стратеги, эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн тэнцвэрт харьцааг хангах макро эдийн засгийн уялдаа, зохицуулалт, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалт, төлбөрийн баланс, эдийн засгийн хамтын ажиллагаа;
- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөө;
- салбарын ба салбар хоорондын, бүс нутгийн хөгжлийн бодлого;
- улсын нэгдсэн төсвийн талаархи судалгаа,

төсвийн төлөвлөлт;

- улсын төсвийн зарцуулалтын удирдлага;
- яам, агентлагийн болон орон нутгийн

төсвийн хяналт;

- бүртгэлийн нэгдсэн тогтолцоог тогтоох, хэрэгжүүлэх ажлын удирдлага;
- гаалийн тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааг оновчтой болгох бодлого;
- татварын орлогын төлөвлөлт, татвар хураалтын ажлын зохион байгуулалт, татварын бодлого;

- улсын даатгалын бодлого;
- гадаадын хөрөнгө оруулалтын бодлого;
- төрийн өмчийн хяналт, бүртгэл;
- стандарт, хэмжил зүйн асуудал.

3/Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд:

- эрх зүйн шинэтгэлийн бодлого;
- хууль тогтоомжийн төсөл боловсруулалтын арга зүй, хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;
- эрх зүйн туслалцаа;
- улсын архив, шүүхийн шийдвэр биелүүлэх, гал түймэртэй тэмцэх асуудал;
- төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;
- иргэний болон иргэний гэр бүлийн бүртгэл, мэдээлэл, иргэний харьяалал, цагаачлалын асуудал;

- хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагын бүртгэл;
- төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
- үл хөдлөх хөрөнгийн бүртгэл;
- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийг хамгаалах асуудал;
- шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж, үйлчилгээ;
- Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, нотариат, өмгөөллийн олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;
- цагдаа, мөрдөн байцаах, улсын хил хамгаалалтын асуудал;

Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2000 оны 8 дугаар сарын 15-ны өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэж хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.

- нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал.

4/Монгол Улсын Байгаль орчны сайд:

- байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
- газрын хэвлийн баялаг, ой ус, ан амьтан, ургамалын нөөцийг хамгаалах бодлого, мэдээллийн сан;

- байгаль орчны шинжилгээ, ус цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах бодлого;

- газар зохион байгуулалтын удирдлага.

5/Монгол Улсын Батлан хамгаалахын сайд:

- улсыг батлан хамгаалах болон цэргийн бодлого;

- зэвсэгт хүчнийг бэхжүүлэх бодлого;
- иргэний хамгаалалтын удирдлага;
- улсын онцгой комиссын ажил.

6/Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд:

- боловсролын тогтолцоог хөгжүүлэх бодлого;

- шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, түүний хэрэгжилт;
- шинжлэх ухаан, технологийн мэдээлэл;
- соёл, урлагийг хөгжүүлэх, түүх соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;
- ном, хэвлэл, цахим бичвэрийн бодлого.

7/Монгол Улсын Дэд бүтцийн сайд:

- түлш, эрчим хүчний бодлого;
- шуудангийн үйлчилгээ, харилцаа холбоо, мэдээллийн технологийн бодлого;

- авто замыг хөгжүүлэх бодлого;
- тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого;
- барилга, барилгын материалын үйлдвэрлэл, хот байгуулалт, усан хангамжийн бодлого;

- орон сууц, нийтийн ахуйн үйлчилгээний бодлого;

- дэд бүтцийн техникийн хяналтын асуудал;
- геодези, зураг зүйн асуудал;
- аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого;

8/Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд:

- хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;

- хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын өртгийн талаархи судалгаа;

- хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн хууль тогтоомжийн улсын хяналт;
- хэрэгшлэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;

- хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, үйлдвэрчний эвлэлийн 3 талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;

- нийгмийн халамжийн бодлого;
- нийгмийн даатгалын бодлого;
- хүн ам зүйн бодлого;
- хүүхэд залуучуудын нийгмийн асуудал;
- малчдын нийгмийн асуудал;
- Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;
- гадаадад ажиллах хүч гаргах асуудал;
- хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт.

9/Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайд:

- эрдэс баялгийн бодлого;

-геологийн бодлого;
 -үндэсний аж үйлдвэрийг сэргээн хөгжүүлэх, үйлдвэрийн бүтцийн бодлого;
 -аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, гадаад зах зээл дээр өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх асуудал;
 -экспорт, импортын асуудал;
 -технологийн бодлого;
 -үйлдвэрлэл, үйлчилгээний тэнцвэрт байдал, хяналт;
 -бөөний худалдаа, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх бодлого;
 -гадаад худалдааны бодлого;
 -газрын тосны талаархи бодлого;
 -худалдааны бодлого, зохицуулалт, хяналт;
 -дэлхийн худалдааны байгууллагын гэрээ, хэлэлцээрээр Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах асуудал.

10/Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайд:

-хүн амын хүнсний хангамжийн бодлого;
 -мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
 -хүнсний аюулгүй байдлыг хангах асуудал;
 -малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх бодлого;
 -газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
 -мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
 -үрийн талаар явуулах бодлого;
 -хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалт;
 -Бэлчээр ашиглалтын болон усан хангамжийн бодлого;
 -шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх асуудал;
 -загас агнуур, далайн баялаг олзворлох асуудал;
 -мал, амьтан, ургамлын хорио цээрийн асуудал;
 -хөнөөлт мэргэчтэй тэмцэх асуудал;
 -улсын нөөцийн асуудал;
 -мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эдийн экспорт, импортын асуудал.

11/Монгол Улсын Эрүүл мэндийн сайд:

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;
 -хүн амын эрүүл мэндийг хамгаалах нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ;
 -эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаархи бодлого;
 -эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого, хяналт;
 -эмнэлгийн үйлчилгээнд тавих улсын хяналт;

-биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого.

12/Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга

-орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлага;
 -Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлт;
 -Засгийн газрын дотоод мэдээлэл;
 -Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал;
 -иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа.

3/21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Ерөнхий сайдын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг Улсын Их Хурлаас Засгийн газрын аль нэг гишүүнд хариуцуулна."

4/34 дүгээр зүйл:

"34 дүгээр зүйл. Ерөнхий сайдын ажлын алба, хэсэг

1.Ерөнхий сайдын дэргэд эдийн засгийн стратеги, төлөвлөлтийн алба ажиллана.

2.Ерөнхий сайд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ зөвлөгөө авах, шуурхай ажил гүйцэтгүүлэх зөвлөхтэй, ажлын хэсэгтэй байна.

3.Ерөнхий сайдын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийг Засгийн газар тогтооно.

4. Ерөнхий сайдын зөвлөх, ажлын хэсгийн ажилтан Ерөнхий сайдад ажлаа шууд хариуцаж, Хэрэг эрхлэх газарт харьяалагдана."

2 дугаар зүйл.Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын тухай хуулийн 36, 37 дугаар зүйлд" гэснийг "Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 15, 16 дугаар зүйлд"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын тухай хуулийн 38, 39, 40, 41 дүгээр зүйл" гэснийг "Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйл"; мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн "төрийн төв хэвлэлд" гэснийг "Төрийн мэдээлэл" эмхтгэлд" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2000 оны 8 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын "Дэд сайд" гэсний дараа "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Засгийн газрын тохируулагч агентлагийн дарга, Ерөнхий сайдын зөвлөх" гэж нэмсүгэй.

дарга" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтаас "Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газрын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 14.1 дэх хэсгийг "Тагнуулын ерөнхий газрын даргыг Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн томилж, чөлөөлнө" гэж өөрчлөн найруулсугай.

газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

3 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгээс "даргыг томилж, чөлөөлнө" гэснийг хассугай.

"5.Цагдаагийн төв байгууллагын даргыг Монгол Улсын Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө."

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "бүтцийг" гэсний дараа "батална" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт,

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хуралдааны

дэгийн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын гишүүн, сайдаар дор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдаар Уламбаярын Барсболдыг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Жүгдэрдэмидийн Гүррагчааг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар Аюурзанын Цанжидийг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдаар Лувсангийн Эрдэнэчулууныг;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн сайдаар Бямбын Жигжидийг;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар

Шийлэгийн Батбаярыг;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Санхүү, эдийн засгийн сайдаар Чүлтэмийн Улааныг;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, худалдааны сайдаар Чимиддоржийн Ганзоригийг;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Цэндийн Нямдоржийг;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар Даржаагийн Насанжаргалыг;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Пагважавын Нямдавааг;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Өлзийсайханы Энхтүвшинг.

2. Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА

Л.ЭНЭБИШ

— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 8 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэж, Монгол Улсын Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулж Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сономцэрэнгийн Мэндсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдын;

Шаравдоржийн Түвдэндоржийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын;

Гаваагийн Батхүүг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайдын;

Ням-Осорын Туяаг Монгол Улсын Засгийн

газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын; Авирмэдийн Баттөрийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэгээрлийн сайдын; Янсанжавын Очирсүхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын; Чойнзонгийн Содномцэрэнг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын;

Дашпунцагийн Ганболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдын;

Содовын Сонинг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА

Л.ЭНЭБИШ

— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 8 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

М.Болдыг Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Урт хугацааны сургалтад хамрагдаж, үүрэгт ажлаа цаашид гүйцэтгэх боломжгүй болсон тул уг

албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасныг нь харгалзан Магваны Болдыг Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

ДАРГА

Л.ЭНЭБИШ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Очирбатын Чулуунбатыг

томилсугай.

2. Энэ тогтоолыг 2000 оны 8 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Хууль, тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэх эсэхийг шийдвэрлээгүй, өргөн мэдүүлсэн хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлагч өөрчлөгдсөн, эдгээр төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын санал шаардлагатай байгаа зэргийг харгалзан хавсралтад дурдсан хууль, Улсын Их

Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчид буцаасугай.

2. Улсын Их Хурлаар нэн тэргүүнд хэлэлцүүлэх шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулж 2000 оны 8 дугаар сарын 25-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА

Л.ЭНЭБИШ

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 17-дугаар тогтоолын хавсралт

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

- | | |
|---|--|
| 1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /1996.11.29/ | 11.Санхүүгийн түрээсийн тухай хуулийн төсөл /1998.09.30/ |
| 2.Монгол Улсын иргэний хувийн өмчийн газрын тухай хуулийн төсөл /1996.12.03/ | 12.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл /1998.12.16/ |
| 3.Газар хувьчлах тухай хуулийн төсөл /1996.12.03/ | 13.Зар сурталчилгааны тухай хуулийн төсөл /1998.12.30/ |
| 4.Хүн амын нутагшлын байршил, хөгжлийн ерөнхий төсөл /1997.01.07/ | 14.Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн төсөл /1999.01.18/ |
| 5.Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /1997.04.04/ | 15.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /1999.05.18/ |
| 6.Төрийн өмчийн орон сууцныг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай хуулийн төсөл /1997.05.14/ | 16.Хаягдал ус зайлуулах, түүнд төлбөр ногдуулах тухай хуулийн төсөл /1999.05.18/ |
| 7.Баяр ёслолын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн төсөл /1997.10.31/ | 17.Цахилгааны тухай хуулийн төсөл /1999.07.02/ |
| 8.Аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл, тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөл /1997.12.25/ | 18.Газрын төлбөрийн тухай хуулийн төсөл /1999.07.02/ |
| 9.Нийгмийн салбарын хувьчлалын тухай хуулийн төсөл /1998.03.12/ | 19.Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /1999.07.20/ |
| 10.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /1998.04.29/ | 20.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд |

- нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / 1999.09.27/
21. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн төсөл /1999.10.01/
22. Архидан согтуурахтай тэмцэх тухай Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан өргөн мэдүүлсэн төсөл 1999.10.06/
23. Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга. 1999.10.08/
24. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл /1999.10.26/
25. "НИК" ХК хувьчлалын тухай /1999.10.26/
26. "ГОВЬ" ХК хувьчлалын санал /1999.10.26/
27. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /1999.12.30/
28. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл /1999.12.30/
29. Галт зэвсгийн тухай хуулийн төсөл /2000.01.12/
30. Иргэний хуулийн төсөл /2000.01.12/
31. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл /2000.01.12/
32. Эрүүгийн хуулийн төсөл /2000.01.12/
33. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөл / 2000.01.12/
34. Шүүхийн тухай хуулийн төсөл /2000-01-12/
35. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / 2000.01.12/
36. Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.01.12/
37. Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.01.12/
38. Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.01.12/
39. Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.01.12/
40. Өвөрхангай аймгийн Тарагт, Арвайхээр сумдыг нэгтгэж Тарагт сум байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /2000.01.12/
41. "АПУ" ХК хувьчлалын санал /2000.01.12/
42. Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /2000.01.12/
43. Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг нөхөн томлох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /2000.01.17/
44. Жирэмслэх үр тогтохоос мэс заслын аргаар сэргийлэх, жирэмслэлтийг хожуу хугацаанд таслан зогсоох тухай хуулийн төсөл /2000.01.21/
45. Эрүүл мэндийн үндэсний бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /2000.01.25/
46. Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын санал / 2000.01.28/
47. "Мальтийн журам"-тай дипломат харилцаа тогтоох тухай /2000.04.06/
48. Худалдааны зохицуулалтын тухай хуулийн төсөл /2000.04.06/
49. Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл / 2000.04.07/
50. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл /2000.04.07/
51. Технологи дамжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан. 2000.04.07/
52. Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан. 2000.04.07/
53. Архивын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан. 2000.04.07/
54. Статистикчлал, чанарын баталгаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан. 2000.04.07/
55. Ариун цэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан. 2000.04.07/
56. Монгол Улсын нөөцийн тухай хуулийн төсөл / 2000.04.24/
57. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Нөөцийн тухай хуультай холбогдуулан 2000.04.24/
58. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.04.24/
59. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.05/
60. Гаалийн тарифийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.05/
61. Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.05/
62. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.15/
63. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.15/
64. Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.15/
65. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.15/
66. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /2000.05.15/
67. Төрийн албан хаагчдын цалингийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /2000.05.15/
68. Санхүүгийн улсын хяналт шалгалтын үйл ажиллагааны тухай хуулийн төсөл /2000.07.06/
69. Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн



Вант Улсын Засгийн газрын хооронд 1998 оны 6 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, сэргийлэх тухай Хэлэлцээр" /2000.07.06/
 70. Монгол Улс, БНБУлсын хооронд 2000 оны 2 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх тухай" Конвенци /2000.07.06/
 71. Монгол Улс, Швейцарын Холбооны Улсын хооронд байгуулсан "Орлого ба хөрөнгийн татварыг

давхардуулж ногдуулахгүй байх тухай" Хэлэлцээр /2000.07.06/
 72. Канад Улсын нийслэл Оттава хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /2000.07.06/
 73. Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /2000.07.18/
 74. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.07.18/

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

1. Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2000.01.10/

Гурав. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

1. Ардчилсан хөдөлгөөн үүссэний ойг тэмдэглэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт нар, 1996.11.07/

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Баттулга, Э.Бат-Үүл, Н.Алтанхуяг нар, 1997.01.30/

3. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал /Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг, 1997.04.16/

4. Хувийн мөрдөлт, хамгаалалтын тухай хуулийн төсөл /Ц.Шаравадорж нар, 1997.05.14/

5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтайван, 1997.06.11/

6. Сүм хийдийн барилга, байгууламж болон эд хөрөнгийг шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Хувьтөгөлдөр нар, 1997.10.13/

7. Ардчилсан хөдөлгөөний ойн өдөр бий болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Отгонбаяр, Д.Хувьтөгөлдөр нар, 1997.11.19/

8. Хууль хүчингүй болсонд тооцох тухай /Улсын Их Хурлын гишүүн Ц.Ганхуяг, Ц.Баярсайхан, Н.Баяртсайхан, С.Төмөр нар, 1998.01.09/

9. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрмаа, Э.Бат-Үүл нар, 1998.01.16/

10. Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Т.Ганди, Ц.Шаравадорж нар, 1998.01.22/

11. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн

Д.Дашпүрэв, 1998.04.03/

12. Батлан хамгаалахын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбаатар, 1998.05.21/

13. Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбаатар, 1998.05.21/

14. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайхан, До.Ганболд, Т.Очирхүү нар, 1998.06.12/

15. Монгол Улсын татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайхан, До.Ганболд, Т.Очирхүү нар, 1998.06.12/

16. Зочид буудлын албан татварын тухай /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайхан, До.Ганболд, Т.Очирхүү нар, 1998.06.12/

17. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Лу.Болд, Е.Гэрэлчулуун нар, 1998.06.24/

18. Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Ганхуяг, С.Баярцогт, С.Ламбаа нар, 1998.07.29/

19. Шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ч.Отгонбаяр, 1998.11.02/

20. Засгийн газрын 172 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтайван, 1998.11.09/

21. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, С.Төмөр нар. 1998.11.27/

22. Түүхэн ойнуудыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Баттулга, Н.Тогтох нар. 1999.01.14/

23. Газар тариалангийн үйлдвэрлэлийн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Өөлд нар. 1999.04.08/

24. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай болон Хуулийн заалт хүчингүй болгох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Батж.Батбаяр, 1999.04.20/

25. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Хувьтөгөлдөр, Д.Энхтайван нар. 1999.05.17/

26. Монголын үндэсний Радио, телевизийн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Ганхуяг нар. 1999.05.22/

27. Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Ганхуяг нар. 1999.05.22/

28. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсантай холбогдуулан "Зарим хууль, тогтоолд өөрчлөлт оруулах, зарим хуулийн заалтыг хүчингүй болгох тухай" хууль, тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Т.Ганди, Г.Ганхуяг нар. 1999.06.18/

29. Ахмад дайчдад хөнгөлөлт үзүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Хувьтөгөлдөр, М.Зэнээ, Д.Энхтүвшин нар. 1999.06.23/

30. Авилгалын эсрэг хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганхуяг нар. 2000.01.10/

31. Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганхуяг нар. 2000.01.10/

32. Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Төмөр нар. 2000.02.04/

33. Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Нарангэрэл, 2000.05.09/

34. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Нарангэрэл, 2000.05.09/

35. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ч.Отгонбаяр, 2000.05.12/

36. Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ч.Отгонбаяр, 2000.05.12/

37. Хэнтий аймгийн Бор-Өндөр дахь сумын прокурорын газрыг сум дундын прокурорын газар болгон өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ч.Отгонбаяр, 2000.05.12/

38. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, С.Ламбаа нар. 2000.05.15/

39. "Монгол Улсын Үндсэн хууль"-ийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнийн Батбаяр 2000.07.04/

40. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн До.Ганболд 2000.07.07/

41. Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтайван 2000.07.07/

42. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтайван 2000.07.07/

43. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтайван 2000.07.07/

44. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтайван 2000.07.07/

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 8 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Керол Беллаийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улсад хүүхэд залуучууд эмэгтэйчүүдийн талаар явуулах төрийн бодлого, хүүхдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж НҮБ-ын Хүүхдийн сангийн

гүйцэтгэх захирал хатагтай Керол Беллаийг "Алтан гадас" одонгоор шагнасангай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

ЗӨВЛӨХИЙГ СОНГОХОД БАРИМТЛАХ ТУСГАЙ ЖУРАМ

Төгсгөл, Түрүүлч № 30-д бий.

Нэг Нийтлэг үндэслэл

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн (цаашид "хууль" гэх) дагуу төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хуулийн дагуу Сангийн яамны худалдан авах ажиллагааг хариуцсан алба, холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага тус тусын чиглэлээр хяналт тавина.

3. Хуулийн дагуу байгуулагдах Тендерийн хороо нь орон тооны бус байх бөгөөд хорооны шийдвэрийг тухайн Тендерийн хороог байгуулсан байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр гаргаж, тамга, тэмдгээр нь баталгаажуулна.

4. Энэхүү журамд заасан "зөвлөх" гэдэг нэр томъёонд зөвлөх компани, инженерийн болон менежментийн компани, олон улсын байгууллага, хөрөнгө оруулалтын болон арилжааны банк, их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, төрийн бус зэрэг байгууллага, хуулийн этгээд, мөн түүнчлэн барилгын менежер, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, хяналт шалгалтын мэргэжилтэн, аудитор зэрэг хувь хүмүүсийг хамруулан ойлгоно. Бодлого боловсруулах зөвлөгөө, байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, менежмент, инженерийн үйлчилгээ, барилгын хяналт, санхүүгийн үйлчилгээ, худалдан авах ажиллагаа, нийгэм, байгаль орчны судалгаа болон дээрх чиглэлийн төслийг тодорхойлох, бэлтгэж боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаанд захиалагчид шаардагдах чадавхийг нэмэгдүүлэхэд туслалцаа авах зорилгоор эдгээр хуулийн этгээд, хувь хүнийг зөвлөхөөр сонгож ажиллуулна.

Хоёр Худалдан авах ажиллагааны төлөвлөлт

5. Зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зохиохдоо холбогдох

бараа, ажил худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэх бөгөөд эдгээр нь хоорондоо уялдсан байна. Зөвлөхийг сонгох ажиллагааны төлөвлөлтийн явцад хэрэглэх маягт, бүдүүвчийг энэ журмын 1, 2 дугаар хавсралтад тусгав.

6. Захиалагч нь төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараа онд худалдан авах зөвлөх үйлчилгээний төслийг боловсруулж дараа оны төлөвлөгөөний төслийн хамт улсын төвлөрсөн төсвийн хувьд Сангийн яаманд, орон нутгийн төсвийн хувьд тухайн шатны Засаг даргад тус тус ирүүлнэ.

7. Төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд түүний удирдлага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) дараа онд худалдан авах зөвлөх үйлчилгээний төслийг зохих журмын дагуу батална.

8. Тухайн жилд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах зөвлөх үйлчилгээний төслийг баталж, холбогдох шийдвэр гарсны дараа захиалагч нь зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох ажиллагааны төлөвлөлтийг бэлтгэнэ.

9. Захиалагч тухайн жилд худалдан авах зөвлөх үйлчилгээний төлөвлөлтийг удирдах дээд шатны байгууллагаар батлуулна.

10. Зөвлөхийг сонгох ажиллагааны төлөвлөлт нь дараахь үе шатуудтай байна:

- худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах;
- худалдан авах зөвлөх үйлчилгээний жагсаалтыг зарлан мэдээлэх;
- Тендерийн хороо болон үнэлгээний хэсгийг байгуулах;
- зөвлөхийг сонгоход хэрэглэх үнэлгээний аргыг сонгох;
- ажлын даалгавар бэлтгэх;
- үнийн тооцоог (тесетв ертег) зохиох;
- шаардлагатай бол зарлан мэдээлэх;
- зөвлөхийн хураангуй жагсаалтыг бэлтгэх;
- саналын урилгыг бэлтгэж, тараах;
- саналыг хүлээж авах;

Энэхүү журам болон худалдан авах ажиллагаатай холбоотой бусад бүх баримт бичигт захиалагч гэдгийг худалдан авах ажиллагааг Засгийн газрын буюу захиалагч байгууллагын нэрийн өмнөөс хэрэгжүүлж буй аливаа байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан/худалдан авах байгууллага, өрөнхий захиалагч, жинхэнэ захиалагч, захиалагчид туслалцаа зорилгоор байгуулагдсан Тендерийн хороо, үнэлгээний хэсэг/ гэсэн өргөн утгаар ойлгоно.

- л) техникийн саналыг үнэлэх;
- м) санхүүгийн саналыг нээх;
- н) санхүүгийн саналыг үнэлэх;
- о) чанарын болон санхүүгийн эцсийн үнэлгээ хийх;
- п) хэлэлцээ хийх, шалгарсан зөвлөхөд гэрээ байгуулах эрх олгох;
- р) гэрээ байгуулах;
- с) гэрээний хэрэгжилт.

11. Захиалагч нь тухайн жилд худалдан авах зөвлөх үйлчилгээний жагсаалтыг өдөр тутмын болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

Гурав.Зөвлөхийг сонгох ажиллагааны зохион байгуулалт

12. Тухайн жилд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах зөвлөх үйлчилгээний төслийг баталсан холбогдох шийдвэр гарсны дараа хуулийн 7 дугаар бүлэгт заасны дагуу Тендерийн хороо болон үнэлгээний хэсгийг байгуулна.

13. Тендерийн хороо нь дарга болон 2-оос доошгүй гишүүнээс бүрдэнэ. Тендерийн хорооны хэлбэр болон бүрэлдэхүүнийг энэ журмын 3 дугаар хавсралтад тусгав.

14. Тендерийн хорооны шийдвэрийн дагуу хорооны даргаас бусад гишүүнийг үнэлгээний хэсгийн гишүүнээр томилж болох боловч тэдгээр нь үнэлгээний хэсгийн 2/3-оос илүү байж болохгүй. Тендерийн хороо, үнэлгээний хэсгийн гишүүн нь тухайн худалдан авах ажиллагаатай ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй этгээд байвал зохино.

15. Үнэлгээний хэсэг нь зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох ажиллагаанд хэрэглэх журмыг сонгох, ажлын даалгавар бэлтгэх, саналын урилгыг зарлан мэдээлэх болон саналыг үнэлэх ажлуудыг гүйцэтгэж, гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлт гаргаж Тендерийн хороонд танилцуулна.

16. Үнэлгээний хэсгийн санал, дүгнэлтийг Тендерийн хорооны хуралдаанаар авч хэлэлцэн гишүүдийн олонхийн саналаар ил санал хурааж, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж гаргана.

17. Захиалагч нь Тендерийн хорооны зөвлөмжийг үндэслэн, гэрээ байгуулах эрхийг уг зөвлөмжийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шалгарсан зөвлөхөд олгоно.

18. Тендерийн хороо аливаа асуудлыг хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ. Тендерийн хороо энэхүү журмын 10-т заасан холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор болон шаардлагатай тухай бүр хуралдана.

19. Тендерийн хорооны хуралдааныг хорооны гишүүдийн 80-аас дээш хувь нь ирсэн тохиолдолд хүчин төгөлдөрт тооцно. Тендерийн хорооны бүх гишүүд саналын тэгш эрх эдэлнэ. Тендерийн хорооны гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хорооны даргын саналаар шийдвэрлэнэ. Цөөнх болсон гишүүн бүрийн саналыг үндэслэлийн хамт Тендерийн хорооны шийдвэрт хавсаргана.

20. Тендерийн хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх бөгөөд хуралдаанд байлцсан бүх гишүүд түүнд гарын үсэг зурж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд хорооны хуралдааны явцын талаар бичлэг хийж болно.

Дөрөв.Худалдан авах ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлага

21. Захиалагч нь зөвлөхийн чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон байх, зөвлөх тухайн ажлыг гүйцэтгэх чадвартай, гэрээний нөхцөл тодорхой, гэрээ хэрэгжих бүрэн үндэслэлтэй байх зэрэг асуудлыг хариуцна. Үүний тулд захиалагч гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах тодорхой хэмжээний эрх мэдлийг зөвлөхөд олгоно.

22. Захиалагчийн зүгээс дотоодын зөвлөхийг сонгон ажиллуулахыг хөхиүлэн дэмжих бодлого баримтална. Шаардлагатай техникийн чадавхи, стандартыг хангасан тохиолдолд дотоодын зөвлөхийг сонгож ажиллуулахыг захиалагч онцгой анхаарна.

23. Зөвлөх үйлчилгээг дотоодын зөвлөхтэй хамтран гүйцэтгэх санал ирүүлсэн хөгжингүй орны зөвлөхийг захиалагч дэмжинэ. Ирүүлсэн саналууд үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ижил хэмжээнд хангасан тохиолдолд дотоодын зөвлөхтэй хамтран ажиллах санал дэвшүүлсэн гадаадын зөвлөхийг илүү үнэлэх чиглэл баримтална.

24. Захиалагч нь дотоод, гадаадын зөвлөхийн хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх боломжтой төсөлд хамтран ажиллах чадвартай дотоодын зөвлөхийн жагсаалтыг тэдний мэргэшил, чадварын тодорхойлолтын хамт хураангуй жагсаалтад орсон гадаадын зөвлөхөд гаргаж өгнө.

Дээрх жагсаалтад орсон дотоодын зөвлөхийн алинтай ч хамтран санал ирүүлэх боломжийг тэдгээр гадаадын зөвлөхөд олгоно. Гэхдээ гадаадын зөвлөх нь дээрх жагсаалтад орсон дотоодын зөвлөхтэй заавал хамтарсан санал ирүүлэх үүрэг хүлээхгүй.

25. Гадаад болон дотоодын зөвлөх хамтран ажиллах тохиолдолд дотоодын зөвлөхийн гүйцэтгэх үйлчилгээг санал болон гэрээнд тодорхой тусгана.

26. Эцсийн зураг төсөл, тооцоо болон техникийн тодорхойлолтыг бэлтгэх үүрэг хүлээсэн зөвлөх үйлчилгээг чанартай, шаардлагын дагуу хийгдсэн болохыг бүрэн хариуцна. Ийм зөвлөхтэй байгуулах гэрээнд энэхүү хариуцлагын талаар зохих заалт оруулна. Бусад зорилгоор сонгогдсон зөвлөх нь захиалагчид техникийн бүх асуудлаар зөвлөмж өгч ажиллах бөгөөд зарим тохиолдолд захиалагч түүнд эцсийн шийдвэр гаргах эрхийг тодорхой хязгаартайгаар олгож болно.

27. Сангийн яамнаас гаргасан холбогдох жишиг саналын урилга, үлгэрчилсэн гэрээний маяг, бусад журмыг захиалагч заавал хэрэглэнэ. Тухайн төслийн онцлогоос шалтгаалан зөвхөн зөвлөхөд өгөх зааварчилгаа болон гэрээний тусгай нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь хууль тогтоомжид нийцсэн, аль болох бага байна. Үлгэрчилсэн гэрээний маягтад талуудын хүлээх хариуцлагыг тусгасан. Зөвлөхийг сонгох ажиллагаанд хэрэглэх жишиг бичиг баримтын жагсаалтыг энэ журмын 4, 5 дугаар хавсралтад тусгав.

28. Зөвлөх нь бодит байдалд тулгуурласан мэргэжлийн зөвлөгөөг өөрийн ирээдүйн ажилтай холбож үзэхгүйгээр үнэнч шударгаар үзүүлэх бөгөөд өөрийн хариуцсан бусад ажил болон ашиг сонирхлын холбоо бүхий этгээдийн сонирхлын зөрчлөөс хатуу зайлсхийх үүрэгтэй. Урьдах, эсхүл одоогийн бусад захиалагчийн өмнө зөвлөхийн хүлээсэн үүрэгтэй холбогдсон сонирхлын зөрчил үүсэхээр тохиолдолд эсхүл энэ нь захиалагчийн шаардлагад бүрэн нийцүүлэн ажиллаж чадахааргүй байдалд зөвлөхийг хүргэх бол түүнийг сонгож ажиллуулахгүй. Дор дурдсан нөхцөлд зөвлөхийг сонгож ажиллуулахыг хориглоно:

а) аливаа төсөлд бараа, ажлыг захиалагчид нийлүүлж байсан этгээд буюу түүнтэй ашиг сонирхлын холбоо бүхий этгээдийг тэрхүү төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Мөн аль нэг төслийг бэлтгэх, хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан этгээд буюу түүнтэй ашиг сонирхлын холбоо бүхий этгээдийг тухайн төслийн эхний үе шатны зөвлөх үйлчилгээтэй холбогдсон

бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхийг (тухайн этгээдийн үзүүлсэн өмнөх зөвлөх үйлчилгээний үргэлжлэлээс бусад) хориглоно. Төрөл бүрийн (зөвлөх, гүйцэтгэгч, нийлүүлэгч) этгээд хамтран түлхүүр гардуулах гэрээ хэрэгжүүлэх тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй;

б) зөвлөх буюу түүнтэй ашиг сонирхлын холбоо бүхий этгээдийн үзүүлэх үйлчилгээ нь зөвлөхийн үзүүлж буй бусад зөвлөх үйлчилгээтэй агуулгын хувьд зөрчилдөх бол түүнийг сонгож ажиллуулахгүй. Тухайлбал: дэд бүтцийн төслийн инженерийн зураг төслийг бэлтгэхээр ажилласан зөвлөхийг тэрхүү төслийн байгаль орчны үнэлгээ бэлтгэхийг, мөн төрийн өмчийг хувьчлахад үйлчлүүлэгчид туслалцаа үзүүлсэн зөвлөхийг энэ өмчийг өөрөө худалдан авах, эсхүл эдгээр өмчийн талаар бусад худалдан авагчдад зөвлөлгөө өгөхийг зөвшөөрөхгүй.

29. Зөвлөх нь хариуцсан үйлчилгээг мэргэжлийн стандартад нийцүүлэн өндөр түвшинд гүйцэтгэнэ. Захиалагчийн өмнө зөвлөхийн хүлээх мэргэжлийн ёс зүйн талаархи үүргийн биелэлтийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

30. Үйлчилгээг хэрэгжүүлэх явцад мэргэжилтнийг солих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд (жишээлбэл мэргэжилтний эрүүл мэндийн байдлаас эсхүл шаардлага хангахгүй болох нь нотлогдвол) зөвлөх тухайн мэргэжилтэнтэй жишихүйц эсхүл түүнээс илүү мэргэшсэн мэргэжилтнийг захиалагчид санал болгоно.

Тав.Зөвлөхийг сонгох ажиллагааны журмууд

Хосолмол үнэлгээний арга

31. Зөвлөхийг сонгох ажиллагаанд ихэвчлэн хосолмол үнэлгээний аргыг хэрэглэнэ. Хосолмол үнэлгээний арга нь хураангуй жагсаалтад хамрагдсан этгээдийн ирүүлсэн саналын чанар (техникийн) болон үнийг (санхүүгийн) харгалзан шалгаруулах өрсөлдөөнд үндэслэнэ. Зөвлөх үйлчилгээний онцлогоос хамааруулан техникийн болон санхүүгийн үзүүлэлтэд өгөх оноог тухай бүр урьдчилан тогтоож хамгийн өндөр нийт оноо авсан зөвлөхийг шалгаруулна.

Бага үнийн арга

32. Хосолмол үнэлгээний аргын хялбаршуулсан хэлбэр бөгөөд аудит, инженерийн ердийн тооцоо, зураг төсөл зохиох зэрэг хэвшмэл үйл ажиллагаатай, төсөвт өртөг нь 10 сая төгрөгөөс хэтрэхгүй байх зөвлөх үйлчилгээнд хэрэглэнэ. Техникийн хувьд тэнцсэн саналуудаас санхүүгийн хувьд хамгийн бага үнэ ирүүлсэн саналыг шууд шалгаруулна.

Чанарын үнэлгээний арга

33. Чанарын үнэлгээний аргыг дараахь төрлийн зөвлөх үйлчилгээнд хэрэглэнэ:

а) цогцолбор, эсхүл тусгайлсан зөвлөх үйлчилгээнд ажлын даалгавар болон зөвлөхөөс гарах үр дүнг нарийвчлан тодорхойлоход хүндрэлтэй, үйлчлүүлэгч зөвлөхөөс шинэлэг санаа (жишээлбэл улс орны эдийн засгийн, эсхүл салбарын судалгаа, хэд хэдэн салбарын техник-эдийн засгийн судалгаа, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийн зураг төсөл, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, санхүүгийн салбарын шинэчлэлт) дэвшүүлсэн тохиолдолд;

б) хамгийн сайн шинжээчийг сонгох шаардлагатай, чухал ач холбогдол бүхий (жишээлбэл, далан зэрэг дэд бүтцийн томоохон хэмжээний байгууламжийн техник-эдийн засгийн болон инженерийн зураг төсөл, улс орны хэмжээний ач холбогдол бүхий бодлого боловсруулах судалгаа, Засгийн газрын томоохон агентлагийн менежментийн судалгаа) зөвлөх үйлчилгээнд;

в) саналуудыг шууд харьцуулах боломжгүй, харилцан адилгүй арга хэлбэрээр хэрэгжүүлэх (жишээлбэл, үйлчилгээний үнэ цэнэ нь задлан шинжилгээний чанараас хамаарах менежментийн зөвлөлтөө, салбарын болон бодлогын судалгаа гэх зэрэг) зөвлөх үйлчилгээнд.

34. Чанарын үнэлгээний арга хэрэглэх үед саналын урилгад техникийн болон санхүүгийн саналыг нэг зэрэг тус тусад нь дугуйнд хийж ирүүлэхийг шаардана. Саналын урилгад төсөвт өртгийг тусгахгүй бөгөөд зөвхөн мэдээлэл болгох зорилгоор голлох боловсон хүчний ажиллах хугацааг тооцоолон заана. Зөвлөх нь өөрийн төсөвт өртгийг чөлөөтэй дэвшүүлэх эрхтэй.

35. Техникийн саналд хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээж гэрээний санхүүгийн болон бусад нөхцөлийг тохиролцооор шууд хэлэлцээ хийнэ. Энэхүү хэлэлцээний дүнд үндэслэн гэрээ байгуулах эрх олгоно.

Зөвлөх хувь хүнийг сонгох

36. Зөвлөх хувь хүнийг ихэвчлэн дараахь тохиолдолд сонгон ажиллуулна:

а) мэргэжилтний баг шаардлагагүй;

б) нэмэлт мэргэжлийн туслалцаа шаардлагагүй;

в) хувь хүний туршлага, чадвар голлох үүрэгтэй.

Үйлчилгээг олон тооны хувь хүмүүс үзүүлэх нь тэдгээрийн зохицуулалт, удирдлага, хамтын үүрэг хариуцлагыг хүндрэлтэй болгох тул энэ тохиолдолд зөвлөх хуулийн этгээдийг сонгож ажиллуулна.

37. Зөвлөх үйлчилгээнд тавигдсан шаардлагад чадвар нь хэрхэн нийцэж байгаад үндэслэн зөвлөх хувь хүнийг сонгоно. Зөвлөх үйлчилгээнд оролцох саналаа илэрхийлсэн хувь хүмүүсийн чадварыг харьцуулах замаар, эсхүл захиалагчид шууд хандсан зөвлөхүүдээс сонгож болно. Захиалагчийн сонгож ажиллуулах зөвлөх хувь хүн нь зохих шаардлагыг хангасан бөгөөд зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй чадавхийг бүрэн эзэмшсэн байна. Чадварыг суурь боловсрол, туршлага, шаардлагатай бол монгол хэл, соёл, зан заншил, засаг захиргааны тогтолцоо, төрийн байгуулалт, орон нутгийн нөхцөлийн талаархи мэдлэг зэргийг үндэслэн үнэлнэ.

38. Зарим тохиолдолд зөвлөх хувь хүн нь зөвлөх хуулийн этгээдийн үндсэн ажилтан, эсхүл зөвлөх хуулийн этгээдтэй хамтран ажиллагч байж болно. Энэ тохиолдолд энэхүү журамд заасан сонирхлын зөрчлийн талаархи заалтууд нь тэдгээр зөвлөх хуулийн этгээдэд мөн адил хамаарна.

39. Зөвлөх хувь хүнийг сонгох журам нь зөвлөх хуулийн этгээдийг сонгох журмаас хялбар байна. Зөвлөх хуулийн этгээдийг сонгоход баримталдаг ажлын даалгаврыг бэлтгэхтэй холбогдсон заалтыг зөвлөх хувь хүнийг сонгож ажиллуулахад хэрэглэж болно. Зөвлөх хувь хүнийг сонгож ажиллуулахдаа дотоодын зөвлөхийг аль болохоор хөхиүлэн дэмжих бодлого баримтална. Зөвлөх хувь хүнийг шууд эсхүл эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, зөвлөх хуулийн этгээд зэрэг аль нэг байгууллагаар дамжуулан сонгон ажиллуулж болно.

40. Зөвлөх хувь хүнийг сонгоход мэдээллийн боломжтой бүх эх сурвалжийг ашиглаж тохирох нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй жагсаалт бэлтгэнэ. Дэлгэрэнгүй жагсаалт бэлтгэх зорилгоор урилгыг өдөр тутмын сонин болон бусад хэвлэл

мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлж болно. Сонирхлоо илэрхийлсэн нэр дэвшигчидтэй холбоо барьж, тэдний тухайн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх сонирхол, бололцоо, чадварыг судална. Хураангуй жагсаалтад 3-аас доошгүй тооны нэр дэвшигчдийг оруулж тэдний чадвар, туршлагад нь үндэслэн байр эзлүүлж, эхний байр эзэлсэн зөвлөх хувь хүнтэй гэрээ болон санхүүгийн нөхцөлийг хэлэлцэж болно. Тохиролцоонд хүрээгүй бол удаахь байр эзэлсэн зөвлөх хувь хүнтэй хэлэлцээ хийнэ (шаардлагатай бол тохиролцоонд хүртэл энэ маягаар үргэлжлүүлнэ).

Зургаа. Саналын урилга

Саналын урилгыг бэлтгэх, тараах

41. Захиалагч Сангийн яамнаас гаргасан жишиг саналын урилгыг хэрэглэнэ. Саналын урилга нь дараахь зүйлээс бүрдэнэ:

- а) урилга;
- б) ажлын даалгавар;
- в) санал болгосон гэрээ;
- г) зөвлөхөд хүргэх мэдээлэл.

Зарлал мэдээлэл

42. Зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт бэлтгэх зорилгоор гэрээ байгуулах гэж буй зөвлөх үйлчилгээний зорилго, захиалагчийн мэдээлэл, санхүүжилтийн эх үүсвэр, саналыг хүлээж авах огноо, цаг, хаяг зэргийг өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр зарлан мэдээлж болно.

Урилга

43. Зөвлөхийг сонгох ажиллагаанд оролцох сонирхлоо илэрхийлж дэлгэрэнгүй жагсаалтад орсон зөвлөхүүдээс чадварын үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг хураангуй жагсаалтад оруулж тэдгээрт саналын урилгыг илгээнэ.

Зөвлөхийн хураангуй жагсаалт

44. Захиалагч хуулийн 27.3.2, 27.3.3-т зааснаар зөвлөхийн хураангуй жагсаалтыг бэлтгэнэ. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх санал ирүүлсэн, холбогдох чадвар бүхий этгээдийг захиалагч эхний ээлжинд авч үзнэ. Хэрэв тухайн зөвлөх үйлчилгээ нь жижиг хэмжээтэй, чадвар бүхий хангалттай тооны (3-аас доошгүй) этгээд өрсөлдөх боломжтой, гадаадын этгээдийг өрсөлдүүлэх шаардлагагүй бол хураангуй жагсаалтад зөвхөн дотоодын зөвлөхийг (өмчийн олонхийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өмчилдөг) хамруулж болно. Гэхдээ гадаадын

этгээд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээ илэрхийлсэн бол түүнийг зөвлөхийг сонгох үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзаж болохгүй.

Ажлын даалгавар

45. Захиалагч тухайн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг бэлтгэнэ. Ажлын даалгаврыг тухайн төрлийн зөвлөх үйлчилгээнд нарийн мэргэшсэн хувь хүн, эсхүл хуулийн этгээд бэлтгэнэ. Ажлын даалгаварт тусгасан үйлчилгээний цар хүрээ нь зөвшөөрөгдсөн төсөвтэй нийцсэн байх шаардлагатай. Ажлын даалгаварт зөвлөх үйлчилгээний зорилго, зорилт, цар хүрээг тодорхой тусгасан байх бөгөөд зөвлөхийг саналаа бэлтгэхэд нь шаардагдах ерөнхий мэдээллээр (одоо байгаа холбогдох судалгааны жагсаалт болон үндсэн өгөгдлүүд гэх мэт) хангасан байна. Төслийн хүрээнд мэдлэг эзэмшүүлэх, эсхүл сургалт явуулах зорилт тавьсан бол түүнд шаардагдах зардлыг төсөвт тооцох боломжийг зөвлөхөд олгох үүднээс тэдгээр сургалтад хамрагдах мэргэжилтний тоо болон бусад мэдээллийг дэлгэрэнгүй заана. Ажлын даалгаварт зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах үйлчилгээ болон судалгааг (жишээлбэл, тайлан, өгөгдөл, газрын зураг, шинжилгээ г.м) жагсаана. Өрсөлдөж буй зөвлөхүүдэд өөрийн арга зүй, боловсон хүчнийг чөлөөтэй санал болгох бололцоог олгох үүднээс ажлын даалгавар уян хатан байна. Ажлын даалгаварт захиалагч болон зөвлөхөд хамаарах үүрэг, хариуцлагыг тодорхой тусгана.

Зардлын тооцоо (төсөвт өртөг)

46. Төсөвт өртгийг боловсон хүчний ажиллах хугацаа, материал техникийн талаар үзүүлэх туслалцаа, шаардагдах хангамж (жишээлбэл, тээврийн хэрэгсэл, лабораторийн тоног төхөөрөмж) зэрэг зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоонд үндэслэн аль болох бодитой тооцно. Зардлыг үндсэн хоёр хэсэгт хуваана:

а) хөдөлмөрийн хөлс (гэрээний төрлийн дагуу);

б) нөхөн төлбөр.

Эдгээр нь дотроо гадаад болон дотоод зардал гэж хуваагдана. Боловсон хүчний зардал нь гадаад болон дотоодын боловсон хүчний ажиллах бодит тооцоонд үндэслэсэн байна.

Гэрээний төрөл

47. Захиалагч Сангийн яамнаас гаргасан үлгэрчилсэн гэрээний маягтыг хэрэглэх бөгөөд тухайн төслийн онцлогийг тусгах зорилгоор өөрчлөлт оруулж болох боловч тэр нь аль болох бага байх зарчим баримтална. Ийм өөрчлөлтийг

зөвхөн гэрээний өгөгдлийн хүснэгт, эсхүл гэрээний тусгай нөхцөлд оруулна. Үлгэрчилсэн маягтад орсон гэрээний ерөнхий нөхцөлд ямар нэг өөрчлөлт хийж болохгүй. Зөвлөхтэй гэрээ байгуулахад дор дурдсан үндсэн хоёр төрлийн гэрээг хэрэглэнэ:

а) Нийт үнэд үндэслэсэн (Тогтоосон үнэтэй) гэрээ. Үйлчилгээний үргэлжлэх хугацаа, агуулга болон зөвлөхөөс шаардах үр дүн нарийвчлан тодорхойлогдсон зөвлөх үйлчилгээнд нийт үнэд үндэслэсэн хэмээг хэрэгчлэн хэрэглэнэ. Энэ гэрээг энгийн төлөвлөлт, техник-эдийн засгийн болон байгаль орчны судалгаа, жишиг ба энгийн бүтээцийн зураг төсөл, тооцоо, мэдээлэл боловсруулах систем бэлтгэх зэрэг зөвлөх үйлчилгээнд өргөнөөр хэрэглэнэ. Төлбөрийг тайлан, зураг төсөл, үнийн жагсаалт, тендерийн бичиг баримт болон компьютерийн программ хангамж зэрэг гарсан үр дүнгийн дагуу хийнэ.²

б) Хугацаанд үндэслэсэн гэрээ. Үйлчилгээний цар хүрээ, үргэлжлэх хугацааг тогтооход хүндрэлтэй, эсхүл гадаад орчны нөлөөллөөс хамааран үйлчилгээг дуусгах хугацаа өөрчлөгддөг, эсхүл тухайн зөвлөх үйлчилгээний зорилтыг хэрэгжүүлэхэд зөвлөхөөс шаардах үр дүнг үнэлэхэд бэрхшээлтэй бол хугацаанд үндэслэсэн гэрээг хэрэглэнэ. Энэхүү гэрээг цогцолбор судалгаа, барилгын ажилд хяналт тавих, зөвлөлгөө өгөх үйлчилгээ болон ихэнх сургалтын үйлчилгээнд хэрэглэнэ. Төлбөр нь мэргэжилтэнд (гэрээнд ихэвчлэн нэрийг заана) цаг, өдөр, долоо хоног буюу сараар төлөх хөлс, бодитой зарцуулсан зардлын нэр төрөл, эсхүл тохиролцсон нэгж үнээр тооцож авах нөхөн төлбөрт үндэслэнэ. Мэргэжилтний хөдөлмөрийн хөлсөнд цалин, нийгмийн болон захиргааны зардал, хураамж (буюу ашиг) болон шаардлагатай бол холбогдох тусгайлан зардал багтана. Энэхүү гэрээнд зөвлөхөд төлөх нийт төлбөрийн дээд хэмжээг заана. Энэ нь урьдчилан таамаглаагүй ажил болон хугацаанаас шалтгаалан гарах магадлашгүй ажлын зардал, шаардлагатай бол үнийн тохируулга хийх зардлыг багтаана.³

Валют

48. Гэрээний валютыг хуульд заасны дагуу саналын урилгад тодорхой заана.

Үнийн тохируулга

49. Гэрээний үргэлжлэх хугацаа 18 сараас илүү бол гадаадын эсвэл дотоодын инфляциас хамааран гэрээнд үнийн тохируулга хийх заалтыг

тусгана. Дотоод, гадаадын инфляци өндөр, эсхүл түүнээс урьдчилан сэргийлэх боломжгүй бол богино хугацаатай гэрээнд ч үнийн тохируулга хийх заалтыг оруулж болно.

Гэрээний төлбөр

50. Төлбөрийн хэмжээ, хуваарь болон журмыг хэлэлцээний үед тохиролцоно. Төлбөрийг тогтоосон тогтмол хугацаанд (хугацаанд үндэслэсэн төлбөртэй гэрээнд), эсхүл тохиролцсон үр дүнгийн дагуу (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй гэрээнд) хийнэ. Гэрээний үнийн 10%-иас хэтэрсэн урьдчилгаа төлбөрийг (жишээлбэл хөрөнгө төвлөрүүлэх үед) урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлсэн нөхцөлд төлнө.

51. Төлбөрийг гэрээний заалтын дагуу шуурхай хийнэ. Төлбөрт маргаантай хэсэг байгаа бол зөвхөн тэр хэсгийг үлдээж, маргаангүй хэсгийн төлбөрийг гэрээний дагуу хийнэ.

Маргааныг таслах

52. Гэрээнд маргааныг хэрхэн таслах тухай тодорхой заана. Томоохон хэмжээний гэрээнд маргааныг таслах арга хэлбэрээр олон улсын худалдааны арбитраж тэргүүн ээлжинд сонгон үзэж болно.

Зөвлөхөд хүргэх мэдээлэл

53. Зөвлөхөд хүргэх мэдээлэлд зөвлөхийг шаардлагад нийцсэн санал бэлтгэхэд шаардагдах бүх мэдээллийг тусгана. Зөвлөхийг сонгох үйл ажиллагааг аль болох ил тод болгох зорилгоор үнэлгээнд ашиглагдах шалгуур үзүүлэлт, бусад хүчин зүйл, тэдгээрийн эзлэх хувийн жин болон авбал зохих онооны доод хэмжээ зэрэг мэдээллийг мөн тодорхой тусгана. Зөвлөхөд хүргэх мэдээлэлд төсөвт өртгийг (үнэ нь үнэлгээний шалгуур үзүүлэлтийн нэг учраас) тусгахгүй, харин голлох мэргэжилтнээс шаардагдах үр чадвар болон боловсон хүчний ажиллах хугацааг заана. Зөвлөх нь зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах боловсон хүчний ажиллах хугацааны талаар өөрийн үнийн тооцоог чөлөөтэй дэвшүүлэх эрхтэй. Зөвлөхөд хүргэх мэдээлэлд саналын хүчинтэй байх хугацааг заана.

54. Захиалагч нь хуульд заасны дагуу Сангийн яамнаас гаргасан зөвлөхөд хүргэх мэдээлэл бүхий жишиг саналын урилгыг хэрэглэнэ.

² Тодорхой гарсан үр дүнгийн дагуу төлбөр хийдэг учир нийт үнэд үндэслэсэн гэрээний хэрэгжилтийг хянаж удирдахад хялбар байдаг.

³ Тухайн зөвлөх үйлчилгээг зохих хэмжээнд хэрэгжсэн, зөвлөхийн нэхэмжилсэн төлбөр бодитой болохыг баталгаажуулах зорилгоор захиалагч хугацаанд үндэслэсэн гэрээний хэрэгжилтийг нарийвчлан хянаж удирдана.

Тухайн төслийн онцлогоос шалтгаалан захиалагч зөвлөхөд хүргэх жишиг саналын урилгаар өгч буй мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол техникийн өгөгдлийн жагсаалтад хийх бөгөөд үндсэн бичвэрт өөрчлөлт оруулахгүй. Зөвлөхөд хүргэх мэдээлэлд зөвлөх үйлчилгээний дараахь гол асуудлын талаар хачгалттай мэдээллийг тусгана:

а) зөвлөх үйлчилгээний товч тодорхойлолт;

б) техникийн болон санхүүгийн саналын жишиг маягт;

в) зөвлөхийн төлөөлөгч нэмэлт тсдруулга авах, холбоо барих, шаардлагатай бол уулзах ажилтны нэр, ханг;

г) зөвлөхийг сонгох дэлгэрэнгүй журам.

Үүнд:

1) хоёр үе шаттай аргыг хэрэглэж байгаа бол түүний тодорхойлолт;

2) техникийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн жагсаалт, тэдгээрийн эзлэх хувийн жин;

3) санхүүгийн үнэлгээний дэлгэрэнгүй заалт;

4) хосолмол үнэлгээний арга хэрэглэх үед техникийн (чанарын) болон санхүүгийн (үнийн) эзлэх харьцангуй хувийн жин;

5) техникийн хуызд хангавал зохих доод оноо;

6) санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх

талаар дэлгэрэнгүй заалт;

д) зөвлөхөд шаардагдах голлох мэргэжилтний түвшин болон төсөвт өртөг (хүн-сараар), санал болгох голлох мэргэжилтнээс шаардах туршлага, болосвол болон мэргэжлийн түвшин, нийт төсөвт өртөг г.м;

е) гадаад санхүүжилтийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл;

ж) хэлэлцээ хийх талаархи мэдээлэл, хэлэлцээний үед сонгосон зөвлөхөөс шаардах санхүүгийн болон бусад мэдээлэл;

з) саналыг ирүүлэх эцсийн хугацаа;

и) үйлчилгээний үнэ өртгийг илэрхийлэх, харьцуулах болон төлбөр хийх валют (валютууд);

к) зөвлөхийн гэрээнд Монгол улсын хууль тогтоомжтой холбоотой тусгайлсан заалт орсон бол түүний ишлэл;

л) зөвлөх үйлчилгээтэй сонирхлын зөрчил үүсгэхээр бол зөвлөх болон түүнтэй ашиг сонирхлын холбоотой этгээдийг төслийн дагуу бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх шаардлага хангахгүй гэж тооцох тухай мэдэгдэл;

м) саналыг ирүүлэх арга хэлбэр, түүний дотор санхүүгийн санал техникийн үнэлгээнд нөлөөлөхгүй байх зорилгоор техникийн болон санхүүгийн саналыг тусад нь битүүмжилж ирүүлэх шаардлага;

н) санал ирүүлэхийг урьсан зөвлөхөөс дараахь зүйлийг хүсэх. Үүнд:

1) саналын урилгыг хүлээж авсан тухайгаа мэдэгдэхийг;

2) санал ирүүлэх эсэх талаар захиалагчид мэдээлэхийг;

о) санал ирүүлэхийг урьсан зөвлөхүүдийн хураангуй жагсаалт, уригдсан зөвлөхүүд хоорондоо хамтрахыг зөвшөөрөх эсэхийг заах;

п) зөвлөхийн санал хүчинтэй байх хугацаа ихэвчлэн 30-60 хоног байна. Энэ хугацаанд зөвлөх нь санал болгосон голлох мэргэжилтэн, нэгж болон нийт үнийг өөрчлөхгүй байх үүрэг, саналын хүчинтэй байх хугацааг сунгасан тохиолдолд зөвлөх саналаа өөрчлөх эрх;

р) шалгарсан зөвлөхөөс үйлчилгээ хлүүлсэн байхаар тооцож буй хугацаа;

с) зөвлөхийн гэрээ болон мэргэжилтэн татвараас чөлөөлөгдөх эсэх тухай заалт; хэрэв чөлөөлөгдөхгүй бол хэдий хэмжээний татвар ногдох, энэ талаархи мэдээллийг хаанаас авч болох тухай болон зөвлөх өөрийн санхүүгийн саналд татварыг тусад нь тооцоолж тусгах тухай заалт;

т) ажлын даалгавар, эсхүл гэрээний төсөлд тусгагдаагүй бол захиалагчаас хангах үйлчилгээ, байгууламж, тоног төхөөрөмж болон мэргэжилтний талаархи дэлгэрэнгүй заалт;

у) зөвлөх үйлчилгээний үе шат (байгаа бол), зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэх шаардлагатай эсэх;

ф) саналын урилгад заасан мэдээллийг тодруулах журам;

х) зөвлөх үйлчилгээний зарим хэсгийг туслан гүйцэтгүүлэх нөхцөл.

Долоо. Саналыг ирүүлэх, хүлээн авах, үнэлэх

Санал ирүүлэх

55. Зөвлөх нь саналын урилгыг хүлээн аваад ажлын даалгаварт заасан шаардлага, арилжааны болон гэрээний нөхцөлийг хангаж чадах бол шаардлагад нийцэх санал бэлтгэхэд шаардлагатай арга хэмжээ (тухайлбал ажлын талбайтай газар дээр нь очиж танилцах, хамтран ажиллах түнш хайх, бичиг баримт цуглуулах, бэлтгэл ажлын баг бүрдүүлэх)-г авна. Саналын урилгын бичиг баримт, түүний дотор сонгох журам, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд хоёрдмол утгатай, зөрчилтэй, тодорхой бус, эсхүл ялгаварласан буюу хязгаарласан зүйл байвал зөвлөх нь саналын урилгад заасан хугацаанд багтаж захиалагчаас бичгээр тодруулга хүсч болно.

56. Шаардлагад бүрэн нийцсэн саналыг саналын урилгад шаардсан бүх бичиг баримтын хамт ирүүлэхийг зөвлөх хариуцна. Үндсэн шаардлагыг хангаагүй байх нь саналаас татгалзах үндэслэл болно.

Саналыг хүлээн авах

57. Захиалагч нь зөвлөхөд санал бэлтгэхэд нь хүрэлцэхүйц хугацааг гаргаж өгнө. Энэ хугацааг тухайн зөвлөх үйлчилгээний онцлогоос хамааран тогтоох бөгөөд ихэвчлэн 30-60 хоног байна. Энэ хугацаанд зөвлөхүүд саналын урилгад тусгасан мэдээллийн талаар тодруулга авахаар хүсэлтээ ирүүлж болно. Захиалагч эдгээр хүсэлтийн хариуг бичгээр үйлдэж, түүний хуулбарыг хураангуй жагсаалтад хамрагдсан бүх этгээдэд илгээнэ. Шаардлагатай тохиолдолд захиалагч саналыг хүлээн авах хугацааг сунгана. Техникийн болон санхүүгийн саналыг нэг зэрэг тус тусад нь дугтуйлан, битүүмжилж ирүүлнэ. Саналыг хүлээн авах эцсийн хугацаанаас хойш техникийн болон санхүүгийн саналд ямар нэг нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглоно. Саналыг хүлээн авах эцсийн хугацааг дуусмагц Тендерийн хороо техникийн санал бүхий дугтуйг нээж, Санхүүгийн саналыг нээхгүй битүүмжилсэн хэвээр үлдээх бөгөөд түүнийг нийтийн өмнө нээх хүртэл Тендерийн хорооны дарга хадгална. Саналыг хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа саналыг нээхгүй шууд

буцаана.

Саналыг үнэлэх

58. Үнэлгээг саналын урилга болон хуультай бүрэн нийцүүлэн явуулна. Саналын үнэлгээг эхлээд техникийн (чанарын), дараа нь санхүүгийн (үнийн) гэсэн хоёр үе шатаар явуулна. Техникийн үнэлгээ дуусч, түүнийг Тендерийн хороо батлах хүртэл үнэлгээний хэсэг санхүүгийн саналыг нээх эрхгүй. Санхүүгийн саналыг зөвхөн техникийн үнэлгээг баталсны дараа нээж.

Техникийн (чанарын) үнэлгээ

59. Захиалагч (үнэлгээний хэсэг) дор дурдсан шалгуур үзүүлэлтийг харгалзан техникийн санал бүрийг үнэлнэ:

а) зөвлөхийн тухайн зөвлөх үйлчилгээтэй холбоотой туршлага;

б) санал болгосон арга зүйн чанар;

в) санал болгосон голлох мэргэжилтний чадвар;

г) мэдлэг шилжүүлэх байдал;

д) зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх голлох мэргэжилтнүүдийн доторхи үндэстний оролцоо.

60. Шалгуур үзүүлэлт бүрт 1-ээс 100 гэсэн тоо хуваарилна. Дараа нь эдгээр тоог холбогдох хувийн жингээр тооцож оноо болгоно. Дор дурдсан хувийн жин нь жишээ бөгөөд тухайн төслийн онцлогоос хамааран өөр өөр байж болно. Хэрэглэх хувийн жинг саналын урилгад тусгана:

Зөвлөхийн тухайлсан туршлага:	5-10 оноо
Арга зүй:	20-50 оноо
Голлох мэргэжилтэн:	30-60 оноо
Мэдлэг эзэмшүүлэх:	0-10 оноо
Үндэстний оролцоо:	0-10 оноо
Нийт:	100 оноо

61. Захиалагч эдгээр шалгуур үзүүлэлтийг ихэвчлэн дэд үзүүлэлтэд хуваана. Жишээлбэл, арга зүйн дэд үзүүлэлт нь шинийг эрэлхийлэх болон нарийвчилсан байдал байж болно. Гэхдээ дэд үзүүлэлт аль болохоор цөөн байвал зохино. Саналын үнэлгээнд хэт нарийвчилсан дэд үзүүлэлт хэрэглэхээс зайлсхийнэ. Зөвлөхийг хураангуй жагсаалтад хамруулахад энэ үзүүлэлтийг урьд нь харгалзан үзсэн учраас туршлагад өгөх хувийн жин

харьцангуй бага байж болно. Цогцолбор зөвлөх үйлчилгээнд (жишээлбэл, олон талыг хамарсан техник-эдийн засгийн болон менежментийн судалгаанд) арга зүйд үнэлгээний илүү хувийн жин өгнө.

62. Зөвхөн голлох мэргэжилтнийг үнэлнэ. Хэрэв санал болгож буй зөвлөх үйлчилгээ цогцолбор бол голлох мэргэжилтэнд үнэлгээний илүү хувийн жин өгнө. Захиалагч голлох мэргэжилтний анкетад тусгасан чадвар, туршлагыг хянаж үзнэ. Саналын хамт ирүүлэх голлох мэргэжилтний анкетыг тодорхой зааж бөглөн бүрэн гүйцэд боловсруулж, зөвлөх болон тухайн хувь хүн гарын үсгээ зурж огноог тэмдэглэнэ. Хэрэв зөвлөх үйлчилгээ нь төслийн удирдагч зэрэг голлох мэргэжилтний үйл ажиллагаанаас шалтгаалах бол ярилцлага явуулна. Хувь хүмүүсийг ажлын даалгавартай уялдсан дор дурдсан 3 дэд үзүүлэлтийн дагуу байр эзлүүлнэ. Үүнд:

а) **ерөнхий чадвар:** боловсролын ерөнхий түвшин, сургалтад хамрагдсан байдал, хэдэн жилийн туршлагатай, эрхэлж байсан албан тушаал, зөвлөх хуулийн этгээдэд үндсэн ажилтнаар ажилласан хугацаа, хөгжиж буй улсад ажилласан туршлага г.м;

б) **зөвлөх үйлчилгээнд тохирох байдал:** тухайн зөвлөх үйлчилгээтэй холбоотой тухайн салбар, чиглэл дэх мэргэжил, боловсрол, сургалтад хамрагдсан байдал, туршлага г.м.;

в) **бус нутгийн туршлага:** орон нутгийн хэл, соёл, засаг захиргааны тогтолцоо, төрийн байгуулалт зэргийн талаархи мэдлэг.

63. Захиалагч санал тус бүрийг ажлын даалгаварт заасан шаардлагатай хэрхэн нийцэж буйг үнэлнэ. Ажлын даалгаварт заасан чухал заалттай нийцээгүй, эсхүл саналын урилгад заасан техникийн саналд авбал зохих доод оноог авч чадаагүй саналыг тохирохгүй гэж үзэн үнэлгээний энэ шатанд тухайн саналаас татгалзана.

64. Эцэст нь захиалагч саналуудын талаар үнэлгээний тайлан бэлтгэнэ. Энэ тайланд үнэлгээний дүнг нотолж, саналуудын харьцангуй давуу болон сул талуудыг тодорхойлно. Үнэлгээний хуудас зэрэг үнэлгээтэй холбоотой бусад тайланг хадгална.

Санхүүгийн (үнийн) үнэлгээ

65. Захиалагч техникийн (чанарын) үнэлгээг дууссаны дараа техникийн (чанарын) доод хэмжээг хангаагүй, эсхүл саналын урилга болон ажлын даалгаврын шаардлагыг хангаагүй санхүүгийн

саналыг нь битүүмжлэгдсэн хэвээр сонгох ажиллагаа дууссаны дараа тухайн зөвлөхөд буцааж хүргүүлэх талаар мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ санхүүгийн саналыг нээх огноо, цагийг чанарын шаардлагыг хангасан зөвлөхүүдэд нэгэн зэрэг мэдэгдэнэ. Санхүүгийн саналыг нээх огноо, цагийг энэхүү мэдэгдэл явуулсан өдрөөс 14-өөс дээш хоногийн дараа байхаар товлон. Нээлтэд оролцохыг хүссэн зөвлөхийн төлөөлөгчийг байлцуулан санхүүгийн саналыг нээнэ. Санхүүгийн саналыг нээхэд зөвлөхийн нэр, техникийн үнэлгээнд авсан оноо, үнийн саналыг чангаар уншиж, тэмдэглэл хөтөлнө. Захиалагч нээлтийн тэмдэглэл хөтөлнө.

66. Нээлтийн дараа захиалагч санхүүгийн саналыг хянаж үзнэ. Хэрэв ямар нэг арифметик алдаа байвал түүнийг засварлана. Саналуудыг харьцуулах зорилгоор хуульд заасны дагуу үнийн саналын урилгад заасан нэг валютад хөрвүүлнэ. Захиалагч ийнхүү хөрвүүлэхдээ саналын урилгыг илгээсэн өдрийн Монгол банкны албан ханшийг баримтална.

67. Үнэлгээ хийхдээ "үнэ"-д дотоодын татварыг тооцохгүй бөгөөд харин томилолт, орчуулга, тайлан хэвлэх, нарийн бичгийн зардал зэрэг нөхөн төлөгдөх зардлыг оруулан тооцно. Хамгийн бага үнийн санал ирүүлсэн саналд санхүүгийн 100 оноо өгч болох бөгөөд бусад саналуудад үнэтэй нь харьцуулан санхүүгийн оноо өгнө. Мөн түүнчлэн шууд харьцуулах болон бусад аргыг хэрэглэж болно. Хэрэглэх арга нь саналын урилгад урьдчилан тодорхойлогдсон байна.

Эцсийн үнэлгээ (техникийн болон санхүүгийн хосолсон)

68. Техникийн (чанарын) болон санхүүгийн (үнийн) оноог тус бүрийн хувийн жинг харгалзан харьцуулж хооронд нь нэмэн нийт оноог гаргана. Зөвлөх үйлчилгээний нарийн түвэгтэй байдал болон чанарын ач холбогдлыг харгалзан "үнийн" хувийн жинг сонгоно. Үнийн хувийн жинд ихэвчлэн 10-20 оноо өгөх бөгөөд нийт 100 онооны 30-аас хэтрэхгүй байна. Техникийн болон санхүүгийн хувийн жинг саналын урилгад тусгана. Хамгийн өндөр нийт оноо авсан зөвлөхийг хэлэлцээнд урина.

Найм.Гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах

Хэлэлцээ хийх ба гэрээ байгуулах эрх олгох

69. Хэлэлцээгээр ажлын даалгавар, арга зүй, боловсон хүчин, захиалагчийн хариуцах хангамж болон гэрээний тусгай нөхцөлийн талаар тохиролцоно. Эцсийн бүтээгдэхүүний

чанар, түүний өртөг болон эхний үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй зорилгоор хэлэлцээний үед анхны ажлын даалгавар, эсхүл гэрээний нөхцөл болзолд зарчмын өөрчлөлт оруулахгүй. Зөвхөн төсөвт нийцүүлэх зорилгоор ажлын цар хүрээг ихээхэн хэмжээгээр бууруулахыг хориглоно. Эцсийн ажлын даалгавар болон үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар тохиролцсон арга зүйг гэрээний хэсэг болох "Үйлчилгээний тодорхойлолтод" тусгана.

70. Сонгох үйл явц хэтэрхий удааширснаас голлох мэргэжилтнийг солих зайлшгүй шаардлагатай гэж талууд тохиролцсон, эсхүл ийнхүү солих нь зөвлөх үйлчилгээний зорилгыг хангахад чухал ач холбогдолтойгоос бусад тохиолдолд шалгарсан зөвлөх голлох мэргэжилтнийг солихыг зөвшөөрөхгүй. Голлох мэргэжилтэн саналдаа өөрийн чадварыг буруу мэдүүлсэн нь тогтоогдвол тэр зөвлөхийг шалгаруулалтаас хасч удаахь байр эзэлсэн зөвлөхтэй хэлэлцээ хийнэ.

71. Татвар хураамжтай холбогдсон асуудлыг гэрээнд хэрхэн тусгахыг санхүүгийн хэлэлцээний явцад тодруулна. Хүн-сарын нэгж үнэ болон нөхөн төлөгдөх зардлын дүнг саналыг үнэлэх хүчин зүйл болгон үнэлгээнд харгалзсан тул онцгой нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд хэлэлцээний үед дахин хэлэлцэж өөрчлөхгүй.

72. Хэлэлцээ амжилтгүй болсон тохиолдолд захиалагч хэлэлцээг зогсоож, удаахь байр эзэлсэн зөвлөхийг хэлэлцээнд урина. Хэлэлцээг зогсоосон үндэслэлийг зөвлөхөд мэдэгдэнэ. Удаахь байр эзэлсэн зөвлөхтэй хэлэлцээ эхэлсэн тохиолдолд өмнөх хэлэлцээг захиалагч дахин үргэлжлүүлэхгүй. Хэлэлцээ амжилттай болмогч захиалагч хураангуй жагсаалтад хамрагдсан бусад зөвлөхөд шалгараагүй тухай нь мэдэгдэнэ.

Бүх саналаас татгалзах, дахин санал урих

73. Ажлын даалгаварт шаардсанаас ихээхэн зөрүүтэй, эсхүл ирүүлсэн үнийн санал нь анхны төсвөөс хэт давсан байснаас шалтгаалж бүх санал шаардлагад нийцээгүй тохиолдолд захиалагч бүх саналаас татгалзах эрхтэй. Ирүүлсэн бүх үнийн санал нь анхны төсвөөс хэт өндөр байсан тохиолдолд төсвийг нэмэгдүүлэх, эсхүл үйлчилгээний цар хүрээг багасгах талаар судалгаа хийнэ.

Нууцлах

74. Саналыг үнэлэхтэй холбогдсон

мэдээлэл, гэрээ байгуулах эрх олгохтой холбогдсон зөвлөмжийг шалгарсан зөвлөхтэй гэрээнд гарын үсэг зурах хүртэлх хугацаанд санал ирүүлсэн зөвлөхүүд болон үнэлгээнд албан ёсоор холбогдолгүй бусад хүмүүст задлахыг хориглоно.

Ес Худалдан авах ажиллагааны хавтаст хэрэг

75. Захиалагч худалдан авах ажиллагаа бүрт бичиг баримтын бүрдлийн хавтаст хэрэг нээж, хөтлөн, архивын нэгж болгон хадгална. Гэрээний хэрэгжилттэй холбоотой бичиг баримтыг тухайн худалдан авах ажиллагааны хавтаст хэрэгт хавсарган хөтөлнө. Худалдан авах ажиллагаа дууссаны дараа дор дурдсан баримтыг зохих журмын дагуу хавтаст хэрэгт бүрдүүлж товъёоглоно. Үүнд:

а) гарын үсэг зурсан гэрээ, хавсралт болон гэрээний өөрчлөлт;

б) урилга болон саналын урилга (холбогдох хавсралтын хамт);

в) шалгарсан зөвлөхийн ирүүлсэн санал (тохиролцсон зүйлс болон нэмэлт нөхцөлийн хамт);

г) сонголтын явцад хийгдсэн хурлын тэмдэглэл, албан бичиг болон бусад холбогдох материал;

д) зөвлөхөөс ирсэн, түүнд өгсөн бичиг захидал;

е) шалгараагүй зөвлөхийн ирүүлсэн санал;

ж) гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэл;

з) Тендерийн хороо болон үнэлгээний хэсгийн хурлын тэмдэглэл, үнэлгээг дүгнэсэн хүснэгт;

и) гэрээний хэрэгжилт, яналт, үнэлгээ болон төлбөрт холбогдох бичиг баримт;


к) бусад зүйл.

Арав Бусад зүйл

76. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгох үйл ажиллагаанд оролцож буй талууд худалдан авах ажиллагааны ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөнө.

77. Зөвлөх нь шалгаруулалтад оролцох болон гэрээ байгуулахдаа авилгал, залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдвол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална. Энэ тохиолдолд захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохоос түр хугацаагаар буюу бүрмөсөн татгалзаж, энэ тухай нийтэд зарлан мэдэгдэнэ.

ЗӨВЛӨХИЙГ СОНГОХ БУДУУВЧ



5	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажиллагаанд Тендерийн хороог тухайн шатны Засаг дарга байгуулна. Уг Тендерийн хороо нь захиалагч байгууллагын төлөөлөгч, санхүүгийн ажилтан, тухайн асуудлыг хариуцсан нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгч, ажлын гэрээний хувьд техникийн бичиг баримт болгтга уургаартай ног буюу хэд хэдэн инженер, зөвлөх инженер, бараа худалдах-худалдан авах гэрээний хувьд тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн болон техникийн шинжээчээс бүрдэнэ.
6	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	Төрийн өмчит үйлдвэрийн газрын	Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлага Тендерийн хороог байгуулж, түүнд Төрийн өмчийн хорооны ажилтныг оруулна.
7	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдлага Тендерийн хороог байгуулж, түүнд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ажилтныг оруулна.
8	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	50%-иас дээш төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн	Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) Тендерийн хороог байгуулна.

Санамж: Тендерийн хорооны дарга Тендерийн хорооны гишүүдийг томилно. Зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг 5'000'001 төгрөгөөс хэтрээгүй тохиолдолд захиалагч байгууллагын дарга худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж, гэрээ байгуулах эрх олгоно.

Зөвлөхийг сонгоход баримтлах тусгай журмын 4 дугаар хавсралт

ЗӨВЛӨХИЙГ СОНГОХ АЖИЛЛАГААНЫ БОСГО ҮНЭ, ТҮҮНД ХОЛБОГДОХ ЖИШИГ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

Сангийн яамнаас гаргасан худалдан авах ажиллагааны журам болон жишиг бичиг баримтыг төсөвт өртөгөөс хамааруулан хэрэглэх зааврыг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Зөвлөхийг сонгох ажиллагаа			
Д/д	Төсөвт өртөг /төгрөг/	Худалдан авах ажиллагааны журам	Худалдан авах ажиллагааны жишиг бичиг баримт
1	5'000'001-10'000'000	Бага үнийн арга	1. Саналын урилга (энгийн) 2. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй)
2	10'000'001-50'000'000	Хосолмол үнэлгээний арга	1. Саналын урилга (энгийн) 2. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй) 3. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (хугацаанд үндэслэсэн төлбөртэй)
3	50'000'001-100'000'000	Хосолмол, эсхүл чанарын үнэлгээний арга	1. Саналын урилга 3. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй) 4. Том хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (хугацаанд үндэслэсэн төлбөртэй) 4. Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй) 5. Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (хугацаанд үндэслэсэн төлбөртэй)
4	100'000'001-ээс дээш	Хосолмол, эсхүл чанарын үнэлгээний арга	1. Саналын урилга 5. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй) 6. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (хугацаанд үндэслэсэн төлбөртэй) 7. Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй) 5. Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний жишиг гэрээ (хугацаанд үндэслэсэн төлбөртэй)



*Зөвлөхийг сонгоход баримтлах
тусгай журмын 5 дугаар хавсралт*

ЗӨВЛӨХИЙГ СОНГОХ АЖИЛЛАГААНЫ ЖИШИГ БИЧИГ БАРИМТ, ҮЛГЭРЧИЛСЭН ГЭРЭЭНИЙ МАЯГТЫН ЖАГСААЛТ

Төрөл	Бичиг баримт
Зөвлөхийг сонгож ажиллуулах	1. Жишиг саналын урилга (ЖСУ)
Үлгэрчилсэн гэрээний маягт	2. Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний үлгэрчилсэн гэрээ (хугацаанд үндэслэсэн төлбөртэй) 3. Томоохон хэмжээний зөвлөх үйлчилгээний үлгэрчилсэн гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй) 4. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний үлгэрчилсэн гэрээ (хугацаанд үндэслэсэн төлбөртэй) 5. Жижиг хэмжээний зөвлөх үйлчилгээний үлгэрчилсэн гэрээ (нийт үнэд үндэслэсэн төлбөртэй)
Жишиг бичиг баримт	Зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагааны үнэлгээний удирдамж
Бусад	Шаардлагатай үед

Санамж: Хуулийн дагуу явагдах бүх гэрээнд мөрдөх жишиг бичиг баримт болон үлгэрчилсэн гэрээний маягтыг Сангийн яам баталж гаргана. Захиалагч эдгээр бичиг баримт, маягтыг мөрдөх үүрэгтэй.

*Засгийн газрын 2000 оны 101
дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт*

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Энэхүү ёс зүйн хэм хэмжээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явцад аливаа төрийн албан хаагчийн зүгээс холбогдох дүрэм, журмыг зөрчиж гажуудал гаргахгүй байх, тэдний нэр төрийг хамгаалах, үйл ажиллагааг нь олон нийтэд нээлттэй, ил тод байлгахад чиглэгдэнэ.

Тендерийн үйл ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагч /цаашид «төрийн албан хаагч» гэх/ нь ёс зүйн хэм хэмжээний дараахь шаардлагыг мөрдөж ажиллана:

1. Сонирхлын зөрчилдөөн байгааг мэдэгдэх

Төрийн албан хаагч өөрийн хариуцсан аливаа ажлыг чин шударгаар гүйцэтгэхэд нөлөөлөх буюу нөлөөлсөн гэж үзэж болох, тухайлбал, тендерт оролцогчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн өмчилдөг, гэр бүлийн этгээд нь энд ажиллаж цалин урамшуулал авдаг гэх мэт ямар нэгэн хувийн сонирхол, шалтгаан байвал энэ талаар өөрийн шууд удирдлага болон тендерийн хорооны даргад бичгээр заавал мэдэгдэнэ.

2. Мэдээллийн нууцлал ба үнэн зөв байдал

Төрийн албан хаагч нь өөрийн ажил үүргийн хуваарь, албан тушаалын дагуу авсан

мэдээллийнхээ нууцыг чандлан хадгалж, түүнийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглаж болохгүй. Төрийн албан хаагчаас тендерт оролцогчдод хуулийн хүрээнд өгөх мэдээлэл үнэн зөв, бүрэн, тэдгээрийг санаатайгаар төвөөрөгдөлд оруулахгүй байвал зохино.

3. Бизнесийн нууцыг хадгалах

Төрийн албан хаагч нь тендерт оролцогчдын ирүүлсэн тэдгээрийн бизнесийн аливаа нууцлалыг бусдад задлах болон ашиглуулж болохгүй.

4. Тендерийн бичиг баримтыг бэлтгэх, гаргах

Төрийн албан хаагч тендерийн бичиг баримтыг аль нэгэн этгээдийн үйл ажиллагааны онцлогт тохируулан бусдын оролцоог хязгаарлах байдлаар бэлтгэж болохгүй бөгөөд боломжит бүх оролцогчдыг хамруулж, тэдгээрийг шударга, чөлөөтэй өрсөлдөх бүхий л нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

5. Шан харамж

Төрийн албан хаагч нь аливаа этгээдийн өмнө ямар нэг үүрэг хүлээх байдалд түүнийг оруулж болзошгүй аливаа шан харамж авах, тэдгээрийн зардлаар цайллага, дайллага, аялал, жуулчлал болон бусад арга хэмжээнд оролцохыг хориглоно. Хэрэв ийм санал ирсэн бол энэ тухай шууд удирдах албан

тушаалтанд мэдэгдэх бөгөөд удирдлагын зүгээс энэ талаар бичгээр үүрэг даалгавар өгсөн тохиолдолд түүнээс үүдэн гарах сөрөг үр дагавар, хариуцлагыг төрийн албан хаагч хариуцахгүй.

6. Үнэлгээний явцад тендерт оролцогчтой харьцах

Тендер шалгаруулалтын шударга байдлыг хангах үүднээс Тендерийн хороо болон үнэлгээний хэсгийн ажилтнаас тендерт оролцогчтой харилцах аливаа харьцаа нь зөвхөн албан ажлын хүрээнд байна.

Төрийн албан хаагч нь тендерт оролцогчийн хүсэлтээр түүнтэй албан ажлын уулзалт хийхдээ гуравдагч этгээдийг байлцуулж ярианы тэмдэглэлийг хөтөлж худалдан авах ажиллагааны хавтаст хэрэгт хавсарган хадгалах бөгөөд хувийг бүх оролцогчдод албан ёсоор хүргүүлж байна.

7. Тендерт оролцогчийг шалгаруулах

Тендерийг харьцуулахад шаардлагатай бүх асуудлыг техникийн тодорхойлолтод тусгасан эсэх, үнэлгээ нь гадны нөлөөгүй явагдсан эсэхийг баталгаажуулах үүднээс техникийн тодорхойлолт болон үнэлгээг Тендерийн хорооны болон үнэлгээний хэсгийн гишүүн бүр давхар хянана.

8. Зөвлөхийг хөлслөх

Захиалагч байгууллага тендер шалгаруулалтыг зөвлөхийн туслалцаатайгаар явуулж байгаа тохиолдолд зөвлөх дээр дурдсан зарчмуудыг мөн адил баримтална. Энэ тухай заалт болон тендер шалгаруулалтын явцад олж авсан мэдээллийг үнэлгээ хийгдсэнээс хойш задруулахгүй хадгалах хугацааг зөвлөхтэй байгуулсан гэрээнд заавал тусгана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Ой тэмдэглэх тухай

Гэгээрлийн яам, Батлан хамгаалах яам, Дайнд оролцогсдын Монголын хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэлхийн П дайны төгсгөл, 1945 оны чөлөөлөх дайны ялалтын 55 жилийн ойг 2000 оны 9 дүгээр сард ёслол тэмдэглэсүгэй.

2. Дэлхийн П дайны төгсгөл, 1945 оны чөлөөлөх дайны ялалтын 55 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай:

Дарга

- Батлан хамгаалахын сайд

Гишүүд: - Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч;

- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн

дарга;

- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Цагдаагийн ерөнхий газрын дарга;

- Үндэсний радио, телевизийн дарга;

- Дайнд оролцогсдын Монголын хорооны дарга (өөртэй нь зөвшилцсөний дагуу).

Нарийн бичгийн дарга

- Засгийн газрын

Хэрэг эрхлэх газрын дарга

3. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг гарган 2000 оны 7 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг комиссын дарга бөгөөд Батлан хамгаалахын сайдад үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Р. АМАРЖАРГАЛ

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд бөгөөд Гэгээрлийн сайдын үүрэг гүйцэтгэгч

С. СОНИН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлтэх үйлдвэрт хэвлэв.

☎ 329487